



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/09

Шивээговь сум

Өвөлжилт хүндэрсэн малчдад өвс, тэжээл
үнэгүй олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/36 дугаар захирамж, сумын Онцгой комиссын 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан зудын гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор өвөлжилт хүндэрсэн малчин өрхөд сумын аюулгүй нөөцөөс үнэгүй олгох өвс, тэжээлийн тоо хэмжээ, хуваарийг 1 дүгээр, хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Малчдад өвс, тэжээл тараах ажлыг чанартай зохион байгуулахыг (Ажлын хэсгийн гишүүд)-д, өвс тэжээлийн тоо ширхэгт хяналт тавьж ажиллахыг нярав (Б.Баярцэцэг)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 17.09 дугаар захирамжийн 01 дугаар хавсралт



Сумын аюулгүй нөөцөд байгаа өвс, тэжээлийн тоо

Сумын нөөц	Өвс	Тэжээл
Шивээговь	1000	100

Аймгийн аюулгүй нөөцөөс хуваарилсан

№	Малчин өрх	Өвс	Тэжээл
Шивээговь	116	160	248

Сумын аюулгүй нөөцөд нийт 1160 боодол өвс, 348 шуудай тэжээлийг үнэ төлбөргүй олгох

Сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын...-ны өдрийн... дугаар захирамжийн... дугаар хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Д.Отгонжаргал
/Засаг даргын Тамгын газрын дарга/

Гишүүд:

П.Ганжаргал
Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн/

Д.Амартүвшин
/Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн/

С.Отгонбаатар
/2-р багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/

Л.Бадамханд
/1-р багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/

Б.Баярцэцэг
/Нярав/

Нарийн бичиг:

Д.Мөнхзаяа
/Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн/